



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.08.09 № 05/6398
танай 2019.08.02 ны № 01/2265

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

Нэрний дарга
2019/8/12

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Татварын ерөнхий газрын харьяа Завхан аймгийн татварын хэлтсийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн Лхамсүрэнгийн Батбаяр, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Батчулууны Золзаяа нарын хувийн ашиг сонирхлын урьчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргуулан шийдвэрлэж, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллуулах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нар нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

Цаашид Төрийн албаны тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, 33 дугаар зүйлийн 33.3-т заасны дагуу тусгай шалгалтанд /тухайн албан тушаалын/ тэнцсэн этгээдийг нэр дэвшүүлэн томилох нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР

Батбаяр



Л.СҮХ-ОЧИР

Батбаяр